

**УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦ НИЙТИЙН  
АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР**

**ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалтын нэр: ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ 5, 16-ИЙН  
ОФФИСЫН ӨРӨӨНҮҮДИЙН ЗАСВАРЫН АЖИЛ**

**Тендер шалгаруулалтын дугаар: ОСНААУГ-БЗА-19/05**

Улаанбаатар хот  
2019 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хэрэглэгчдэд үйлчлэх төв 5, 16-ийн оффисын өрөөнүүдийн засварын** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө** цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 11 цаг 00 минутад нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**  
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.  
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
4. Тендерийн үнэ 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.  
  
4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.  
  
4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон

нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Үнийн санал /Маягтын дагуу ирүүлэх/</p> <p>2. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон ажлын төсөв /Мэргэжлийн төсөвчнөөр хийлгэж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх/</p> <p>3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p> <p>4. НӨАТ төлөгч байх ба гэрчилгээний хуулбар</p> <p>5. Барилга, хот байгуулалтын яамны:</p> <p><b>БА-8.1</b> Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил</p> <p><b>БА-2.1.</b> Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил</p> <p>6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд нь доод тал нь нэг удаа ижил төстэй ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. Гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын талаар доорх нотлох баримтуудыг ирүүлнэ.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар</li> <li>- Ажил хүлээлцсэн актын хуулбар</li> <li>7. 2018 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан</li> <li>8. Харьяалагдах татварын газрын тодорхойлолт</li> <li>9. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>10. Ажилчдын танилцуулга дипломны хуулбар /ажлын туршлага харуулсан баримт бичиг</li> </ul>

	<p>11. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж. Их тойруу. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p><a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a></p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж. Их тойруу. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p><a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a></p> <p>Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>Хэрэглэгчдэд үйлчлэх төв 5, 16-ийн оффисын өрөөнүүдийн засварын ажил</b></p> <p>ОСНААУГ-БЗА-19/05</p>

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>1. Байршил</b>	<b>ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ 5, 16-ИЙН ОФФИСЫН ӨРӨӨНҮҮДИЙН ЗАСВАРЫН АЖИЛ</b>
<b>2. Ажлын цар хэмжээ</b>	Энэхүү гэрээнд <b>Ажлын тоо хэмжээ</b> гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ
<b>3. Дээврийн засварын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг төслийн менежерт үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл холбогдох газруудад туршилт, шахалтуудыг хийлгэх зөвшөөрлийг авч ил, далд, ажлын акт, гүйцэтгэлийн фото зураг үйлдснээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ.</li> <li>• Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.</li> <li>• Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.</li> <li>• Дээврийн ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтанд өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.</li> <li>• Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хайлмал материалын техникийн ерөнхий шаардлагыг MNS 6303:2016 стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.</li> <li>• Барилгын норм дүрмийн БД 31-108-08 Битум полимер материалаар дээврийн хучлага төлөвлөх ба гүйцэтгэх нормын дараах заалтуудыг мөрдөн ажиллана. <ul style="list-style-type: none"> <li>2.11 Ус тусгаарлах гадна үе</li> <li>2.13 Дээвэр дээр илүү гарсан янданд хайлмал холбох</li> <li>2.14 Барилгын дээврийн температур хэв гажилтын ан</li> <li>3.1.1-11 Дээврийн ажлыг гүйцэтгэх, хүлээн авах</li> <li>5.1 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа</li> </ul> </li> </ul>

## Тав. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ

1. Барилгын засварын ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртлэх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина.
2. Материалын чанарт хяналт тавих
3. Ажлын явцад гарах зураг, төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлэх.
4. Магадлашгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн менежерийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон, төсөв тооцоо хийж /шаардлагатай бол зураг хийх/ баталгаажуулж санхүүжүүлэх.

## Зургаа. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

1. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээ, зургийн дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан, акт үйлдэнэ.
3. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
4. Мөн байгалийн гэнэтийн гамшиг, гол түймэр, үер усны гамшгаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна.
5. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх.
6. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүн хавсаргаж ирүүлнэ. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн, бетон зуурмагийн дээжээс сорилын шоо авч лабораторийн дүгнэлт гаргуулсан байна.
7. Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Дээрх ажлын тоо хэмжээнд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Долоо. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

ХҮТ-16

**ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Шавардлагатай таазыг гар аргаар ердийн чанартай будах	м2	218
	Шавардлагатай хананд цавуун будгаар, гар аргаар өндер чанараар будалт хийх	м2	463
	Шавардсан ба бетон хана өнгийн тосон будгаар будах	м2	463
	2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	ш	1
	Вакум хаалт угсралт	хавтас	2
	Зүймэл банзаар /царсан/ шал хийх	м2	60
	2.2x1.4 хэмжээтэй пластмасан цонх гараар угсралт	блок	3
	1.4x1.4 хэмжээтэй пластмасан цонх гараар угсралт	блок	6
	Маяг-10 панел (ялтсан) радиатор h- 300-500 l-400-3000 мм-ийг угсралт	ш	6

**00 ОРООННИЙ ЗАСВАРЫН АЖИЛ**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Холигч байрлуулах	ш	2
	Шаазан зайлах торхтой суултуур байрлуулах	ком	2

**ШАЛНЫ АЖИЛ**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Зүймэл банзаар /царсан/ шал хийх	м2	80.9

**ЗАСВАРЫН АЖИЛ**

Үндэслэл	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Хана таазны гадаргууг зүлгэж өнгөлөх	м2	93.8
	Шавардсан хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м2	128.3
	Шавардлагатай таазыг цавуун будгаар, гар аргаар сайн чанартай будах	м2	93.8
	2м2 хүртэл талбайтай хаалга суулгах	ш	3
	1.6x1.4 хэмжээтэй пластмасан цонх гараар угсралтад	1 блок	4

## Найм. ЖИШИГ МАЯГТ

## ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч<br>ажил<br>гүйцэтгэх                                  | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| 2. Төслийн<br>менежерийн<br>шийдвэр                                 | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй х олбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| 3. Ажил<br>дуусгахаар<br>төлөвлөсөн<br>өдөр ажил<br>дууссан<br>байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| 4. Аюулгүй<br>байдал  | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилг<br>аа   | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| 6. Маргааныг<br>шийдвэрлэх  | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ
7. Ажлын хөтөлбөр
- 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
- 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. Зөрчил, гологдол илрүүлэх
- 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. Зөрчил, гологдол арилгах
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил,
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

гологдол мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол  
арилгахгүй төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах  
байх зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Ye шатны 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе  
ажлын шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор  
хуваарь бэлтгэж ирүүлнэ. Ye шатны ажлын хуваарьт тусгагдсан  
үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл  
ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх  
бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын  
тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж  
ирүүлнэ.
12. Ye шатны 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл  
ажлын ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор  
хуваарийг гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт  
хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь  
үнийг өөрчлөхгүй.
13. Алданги 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа  
хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан  
хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн  
гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс  
хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх  
төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь  
гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо	<p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p>
17. Ашиглалт, засвар, үйлчилгээни й гарын авлага	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
18. Гэрээг цуцлах
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг

хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

- 19.Гэрээг цуцалсан үед хийх төлбөр
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20.Гүйцэтгэлээ с чөлөөлөх
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

#### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Хэрэглэгчдэд үйлчлэх төв 5, 16-ийн оффисын өрөөнүүдийн засварын ажил ОСНААУГ-БЗА-19/05</b>
---------	---

ГЕН 3.1	Төслийн менежерийг Захиалагч томилно
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна.
	Нийт ажилд ноогдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 14 өдрийн дотор гаргаж өгнө
	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200 000 /Хоёр зуун мянга төгрөг/ байна

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний өрөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

**ТАМГА**

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ТАМГА**

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]